



MN

Хурууны хээ Ба Eurodac

Гишүүн оронд хууль бусаар оршин суугаа гуравдагч орны иргэн юм уу, хярьяалалгүй хүнд зориулсан 603/2013 тоот (ЕХ) Тогтоолын 29(3)-р зүйлийн дагуу өгөх мэдээлэл

Хэрвээ та Дблины оронд¹⁾ хууль бусаар оршин суугаа бол албаны хүмүүс таны хурууны хээг авч, үүнийгээ 'Eurodac' хурууны хээний мэдээллийн сан руу шилжүүлдэг. Үүний цорын ганц зорилго нь таныг орогнол хүсэх өргөдөл гаргасан эсэхийг тодорхойлох явдал юм. Таны хурууны хээг Eurodac мэдээллийн санд хадгалаагүй бөгөөд та өөр орноос орогнол хүссэн тохиолдолд таныг тэр орон руу буцаана.

Хэрвээ бусад шалтгаанаар, ялангуяа хуруугаа гэмтээсний улмаас таны хурууны хээ чанар муутай байвал хурууны хээг дахин авна.

Eurodac-ийг eu-LISA хэмээх Европын Холбооны агентлаг ажиллуулдаг. Таны мэдээллийг зөвхөн хуульд заасан зорилгоор ашиглаж болно. Таны мэдээллийг зөвхөн Eurodac төв систем хадгална. Хэрвээ та ирээдүйд Даблины журмын өөр орондорогнол хүсэх өргөдөл гаргавал таны хурууны хээг авч Eurodac руу дамжуулна. Eurodac дотор хадгалсан мэдээллийг Дублины оронд хамаарахгүй бусад улс юм уу, байгууллагатай солилцохгүй.

- 1) Европын Холбоог бүхэлд нь хамаарна (Австри, Бельги, Болгар, Хорват, Кипр, Бүгд Найрамдах Чех Улс, Дани, Эстони, Финланд, Франц, Герман, Грек, Унгар, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Мальта, Нидерланд, Польш, Португали, Румин, Словак, Словени, Испани, Швед, Их Британи) болон Дублины журамтай 'холбоотой' дөрвөн улс (Норвеги, Исланд, Швейцарь, Лехтенштейн).

© Европын Холбоо 2014

Дахин хувилахыг зөвшөөрөв. Фото зураг бүрийг ашиглах юм уу хуулбарлах зөвшөөрлийг зохиогчийн эрх эзэмшигчээс шууд авч болно.

Холбоо барих дэлгэрэнгүй мэдээлэл

**Дүрвэгсдийн асуудал
эрхэлсэн байгууллагын хаяг
ба дэлгэрэнгүй мэдээлэл**
Bundesamt für Migration und
Flüchtlinge (BAMF)
Frankenstraße 210
90461 Nürnberg
Утас.: +49 (0)911 943 0
Факс: +49 (0)911 943 10000
Email: service@bamf.bund.de

**Eurodac шалгагчийн хаяг ба
дэлгэрэнгүй мэдээлэл**
Bundeskriminalamt (BKA)
65173 Wiesbaden
Утас.: +49 (0)611 55 0
Факс: +49 (0)611 55 12141
www.bka.de

Хэрвээ манай албаны хүмүүс таныг өөр орноос орогнол хүссэн, өөр орон таны өргөдлийг шалгах үүрэгтэй гэж сэжиглэвэлд тэд танд дараагийн авах арга хэмжээ, энэ нь та болон таны эрхэнд хэрхэн нөлөөлөх талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.



**‘Би Дублины журамд
хамаарагдаж байгаа
юм байна – Энэ юу
гэсэн үг юм бол?’**

Дублины журмын дагуу орогнол хүсэгчдэд зориулсан 604/2013 тоот (ЕХ) Тогтоолын 4-р зүйлийн дагуу өгөх мэдээлэл